НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 22 өдөр Дугаар А/20 Улаанбаатар хот

Зочид буудал, зоогийн газрын үзэсгэлэн,
зочлох үйлчилгээний салбарын
мэргэжлийн аварга шалгаруулах
"Хорека" олон улсын тэмцээн зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого батлах тухай" 333 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09, 02/10 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/530 дугаар захирамж, тус газрын 2022 оны дүрмийн 4.1.8, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Зочлох үйлчилгээний салбарт инновацийг нэвтрүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, туршлага солилцох, ажил мэргэжлийг сурталчлах зорилгоор "Зочид буудал, зоогийн газрын үзэсгэлэн, зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн"-ийг 2022 оны 05 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 42.300.000 /дөчин хоёр сая гурван зуун мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргалд/-д зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг /Х.Содномдэмбэрэл/-т даалгасугай.

ДАРГА Д.БАТСҮХ

1150590167

D:\NAJG 2022\A tushaal tusul\2022.04.22 A20.docx

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 04 сарын 22-ны өдрийн
А/20 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Х.Содномдэмбэрэл	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд:	С.Мөнхбат	Монголын Зочид буудлуудын холбооны ерөнхийлөгч
	Н.Батцэнгэл	Монголын Зочид буудлуудын холбооны гүйцэтгэх захирал
	Г.Нэрэн	Монголын Бартендер бариста мэргэжилтний холбооны тэргүүн
	Г.Мөнгөндолгио	Монголын Зочлох үйлчилгээний холбооны эксперт
	Д.Ганболд	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
	Г.Анхбаяр	Ай хотел ХХК-ийн хөгжлийн менежер
	Б.Ариунзаяа	Санхүү, эдийн засгийн их сургуулийн соёл иргэншил, аялал жуулчлалын тэнхимийн багш
	Б.Гэрэлмаа	Монголын Зочид буудлуудын холбооны менежер
Нарийн бичгийн дарга:	Э.Мөнхзул	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 04 сарын 22-ны өдрийн
А/20 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Зочид буудал, зоогийн газрын үзэсгэлэн, зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн аварга шалгаруулах "Хорека" олон улсын тэмцээн зохион байгуулах зардлын төсөв

2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төг/	Нийт үнэ /төг/	Тооцоо хийх хэлбэр
1	Телевизийн сурталчилгааны шторк, арга хэмжээний нэвтрүүлэг, мэргэжил тус бүрээр видео сургалтын гарын авлага бэлтгэж гаргах	3 төрөл /3 өдрийн бичлэг/	10.000.000	10.000.000	Нэхэмжлэх
2	Телевизүүдээр шторк цацах	6	500.000	3.000.000	Нэхэмжлэх
3	Үзэсгэлэнгийн талбайн түрээс, тайз, дэлгэц, хөгжим	2 өдөр	9.000.000	18.000.000	Нэхэмжлэх
4	Хэвлэлийн эх бэлтгэл, хэвлэх /Урилга, хөтөлбөр, мандат/	4 төрөл	500.000	500.000	Нэхэмжлэх
5	Урлагийн тоглолт	багц	1.000.000	1.000.000	Нэхэмжлэх
6	Зочилох үйлчилгээний салбарын мэргэжлийн холбоод, зочид буудал, тур оператор компаний чуулга уулзалт форум	2 /танхим түрээс/	3.000.000	3.000.000	Нэхэмжлэх
7	1.Тайзны хөтлөгч 2.Тэмцээний хөтлөгч	2 өдөр 3 өдөр	750.000 800.000	1.500.000 800.000	Бэлэн
8	Шүүгч нарын ажлын хөлс	10 хүн /3 өдөр/	250.000	2.500.000	Бэлэн
9	Оролцогчдын энгэрийн тэмдэг	200	2,500	500,000	Нэхэмжлэх
10	Стэнд зөөх тээврийн зардал	2	150.000	300.000	Нэхэмжлэх
11	Зочид буудал, зочлох үйлчилгээний ангийн оюутнуудын дунд зохион байгуулах олимдиадын шүүгчийн зардал	6 хүн	200.000	1.200.000	Нэхэмжлэх
Дүн				42.300.000	

--o0o--